

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Манхан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/90/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: А.Оюундэлгэр

Утас: 99306289

цахим хаяг: a\_ojund@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбостой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
64000 Цамбогжав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 978-7043369, Факс: 978-7043361  
E-mail: khovd@audit.gov.mn

МАНХАН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.ХИШИГСАЙХАН ТАНАА

2022.02.17 № 02/20  
Танай \_\_\_\_\_ Чим № \_\_\_\_\_

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Манхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын эс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>53,809,239</u></b>	<b><u>64,840,296</u></b>
335	Бусад авлага	450,837	536,512
3351	Байгууллагаас авах авлага	450,837	499,962
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0	36,550
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>53,358,402</b>	<b>64,303,784</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>0</b>	<b>171,000</b>
35130	Эм боох материал	0	171,000
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>53,358,402</b>	<b>64,132,784</b>
35410	Бичиг хэргийн материал	75,100	181,100
35420	Аж ахуйн материал	8,006,700	8,022,882
35440	Түлш, шатах тослох материал	1,718,000	2,033,000
35460	Хүнсний материал	6,673,347	12,505,197
35470	Бусад хангамжийн материал	36,885,255	41,390,605
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,443,187,267</u></b>	<b><u>1,419,783,947</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,443,187,267</b>	<b>1,419,783,947</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,435,369,267</b>	<b>1,411,965,947</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,423,320,512	1,428,320,512
39202	Хуримтлагдсан элэгдэл	-34,398,420	-72,073,450
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,404,820	62,445,533
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,177,264	-29,234,961
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,888,597	44,665,646
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,888,978	-22,377,333
39217	Ном	220,000	220,000
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>7,818,000</b>	<b>7,818,000</b>
39301	Програм хангамж	550,000	550,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000	-550,000
39303	Бусад биет бус хөрөнгө	8,093,000	8,093,000
39304	Хуримтлагдсан элэгдэл	-275,000	-275,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,496,996,506</u></b>	<b><u>1,484,624,243</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>839,357</u></b>	<b><u>22,850</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>839,357</b>	<b>22,850</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>839,357</b>	<b>22,850</b>

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,450	22,850
4136	Бусад өглөг	833,907	0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	833,907	0
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,496,157,149</b>	<b>1,484,601,393</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,496,157,149	1,484,601,393
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	313,113,072	313,113,072
51101	Өмч: - төрийн	305,295,072	305,295,072
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	7,818,000	7,818,000
512	Хуримтлагдсан үр дүн	1,144,246,940	1,132,691,184
51210	Өмнөх үеийн үр дүн	1,144,246,940	1,144,246,940
51220	Тайлант үеийн үр дүн	0	-11,555,756
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,797,137	38,797,137
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,496,996,506</b>	<b>1,484,624,243</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>412,440,705</b>	<b>445,168,031</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>369,547,105</b>	<b>30,367,033</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	38,446,605	30,367,033
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,446,605	30,367,033
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,446,605	30,367,033
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>42,893,600</b>	<b>52,169,198</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331100500	362,631,800
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0	9,213,098
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	9,213,098
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	42,893,600	42,956,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,893,600	42,956,100
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>375,119,477</b>	<b>456,709,087</b>

21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>375,119,477</b>	<b>456,709,087</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>320,689,424</b>	<b>387,446,860</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>219,504,106</b>	<b>244,555,807</b>
210101	Үндсэн цалин	196,574,590	174,188,032
210102	Нэмэгдэл	6,000,000	48,228,600
210104	Урамшуулал	16,929,516	22,139,175
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,429,015</b>	<b>32,165,931</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,657,849	22,377,619
210202	Тэтгэмжийн даатгал	2,150,532	2,462,359
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,793,459	1,969,887
210204	Ажилгүйдлийн даатгал	437,094	488,654
210205	Эрүүд мэндийн даатгал	4,390,081	4,867,412
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,925,115</b>	<b>40,534,171</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,888,815	1,728,871
210302	Түлш, халаалт	38,735,300	38,735,300
210303	Цэвэр, бохир ус	301,000	70,000
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,206,775</b>	<b>1,651,895</b>
210401	Бичиг хэрэг	103,900	57,100
210402	Тээвэр, шатахуун	618,975	578,895
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,000	73,400
210404	Ном, хэвлэл	6,000	13,200
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	0	430,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	452,900	499,300
2105	<b>Нормативт зардал</b>	<b>21,874,971</b>	<b>17,241,423</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	246,500
210502	Хоол, хүнс	20,859,671	15,778,450
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,015,300	1,216,473
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>312,000</b>	<b>438,200</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,000	114,200
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	324,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,437,443</b>	<b>50,859,433</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,000	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,788,727	449,185
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,550,716	50,410,248
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>8,504,010</b>

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	8,504,010
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	59,485,188
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	59,485,188
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,430,053	1,273,029
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,430,053	1,273,029
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	37,321,228	-11,541,056
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	14,700
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0	14,700
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0	-14,700
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	37,321,228	-11,555,756

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний ноц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	313,113,072	38,797,137	-73,126,320	278,783,889
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	313,113,072	38,797,137	-73,126,320	278,783,889
C07	Тайлант үеийн үр дүн	0	0	37,321,228	37,321,228
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313,113,072	38,797,137	1,144,246,940	1,496,157,149
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313,113,072	38,797,137	1,144,246,940	1,496,157,149
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	313,113,072	38,797,137	1,144,246,940	1,496,157,149
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	-11,555,756	-11,555,756
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313,113,072	38,797,137	1,132,691,184	1,484,601,393

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	377,535,850	414,800,998

120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,541,750	0
120009	Бусад орлого	3,541,750	0
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	331,100,500	0
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	331,100,500	0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>42,893,600</b>	<b>414,800,998</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	362,631,800
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	9,213,098
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,213,098
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	42,893,600	42,956,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,893,600	42,956,100
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>377,535,850</b>	<b>414,800,998</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>377,535,850</b>	<b>414,800,998</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>323,105,797</b>	<b>345,538,771.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	221,556,564	244,614,200
210101	Үндсэн цалин	143,731,408	156,417,900
210102	Нэмэгдэл	61,041,656	71,132,500
210104	Урамшуулал	16,783,500	17,063,800
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,373,929	32,126,688
210201	Тэтгэврийн даатгал	17,885,749	22,362,023
210202	Тэтгэмжийн даатгал	1,860,977	2,448,569
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,509,434	1,958,617
210204	Ажилгүйдлийн даатгал	335,592	485,937
210205	Эрүүл мэндийн даатгал	3,782,177	4,871,542
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,869,979	40,849,171
210301	Гэрэл, цахилгаан	1,718,679	1,728,871
210302	Түлш, халаалт	38,735,300	39,050,300
210303	Цэвэр, бохир ус	416,000	70,000
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,454,825	1,962,888
210401	Бичиг хэрэг	113,500	88,600
210402	Тээвэр, шатахуун	942,925	515,700
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,000	73,400
210404	Ном, хэвлэл	6,000	22,200

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	478,088
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	367,400	784,900
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31,505,200</b>	<b>24,411,224</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,242,720	252,000
210502	Хоол, хүнс	25,576,980	21,610,350
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,685,500	2,548,874
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0</b>	<b>833,900</b>
210604	Урсгал засвар	0	833,900
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>312,000</b>	<b>438,200</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,000	114,200
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	324,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,033,300</b>	<b>302,500</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,000	00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,935,300	302,500
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,430,053</b>	<b>69,262,227</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>8,504,010</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	8,504,010
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>59,485,188</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	59,485,188
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>54,430,053</b>	<b>1,273,029</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,430,053	1,273,029
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	405,587,900	344,829,683
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	405,587,900	344,829,683
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	405,587,900	344,829,683
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	265,721,900	244,614,200
210101	Үндсэн цалин	164,659,900	156,417,900
210102	Нэмэгдэл	83,998,200	71,132,500
210104	Урамшуулал	17,063,800	17,063,800
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,872,500	32,126,688
210201	Тэтгэврийн даатгал	25,243,800	22,362,023
210202	Тэтгэмжийн даатгал	2,657,200	2,448,569
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,125,700	1,958,617
210204	Ажилгүйдлийн даатгал	531,400	485,937
210205	Эрүүл мэндийн даатгал	5,314,400	4,871,542
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,122,200	40,849,171
210301	Гэрэл, цахилгаан	2,364,900	1,728,871
210302	Түлш, халаалт	39,085,300	39,050,300
210303	Цэвэр, бохир ус	672,000	70,000
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,623,400	1,484,800
210401	Бичиг хэрэг	169,200	88,600
210402	Тээвэр, шатахуун	519,300	515,700
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,600	73,400
210404	Ном, хэвлэл	59,600	22,200
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	789,700	784,900
2105	<b>Нормативт зардал</b>	53,734,200	24,180,224
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,800	21,000
210502	Хоол, хүнс	50,642,100	21,610,350
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,029,300	2,548,874
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	833,900	833,900
210604	Урсгал засвар	833,900	833,900
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	107,900	0
210702	Дотоод албан томилолт	107,900	0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	467,600	438,200
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600	114,200
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000	324,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	510,430	302,500
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,104,300	302,500
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	405,587,900	405,587,900
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	362,631,800	362,631,800

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	362,631,800	362,631,800
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	42,956,100	42,956,100
132001	Орон нутгийн төсвөөс	42,956,100	42,956,100
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	0	0
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	21	21
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	0	0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	21	21
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	16	16
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Манхан сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуультай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор А.Оюундэлгэр 2022 оны 01 дүгээр сарын 25-нээс 2021 оны 01 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Манхан сумын хүүхдийн цэцэрлэг нь сумын 2-5 насны бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хэмруулан сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулж цэцэрлэгийн хамран сургалтыг 0,5 хувиар ахиулж, үндсэн болон хувилбарт, явуулын чиглэлээр үйлчилгээг хүргэж хамтарч ажиллах, Монгол улсын засгийн газраас баталж гаргасан тогтоол, шийдвэр, аймаг суманд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, үр дүнг нээлттэй болгон ажиллаж байгаа сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Тус байгууллага нь 2021 онд "Хүүхдийн бүтээлч үйлийг дэмжсэн орчин бий болгон, сургалт үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, бүх талын хамтын ажиллагаа, оролцоо хангах" зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2019 оноос шинэчлэгджээ.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Хяналт шинжилгээ үнэлгээ аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Манхан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт орлогын 445.1 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 8,9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Манхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,4 сая төгрөгөөр буюу 0,8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант оны эхэнд 0,4 сая төгрөгийн авлагатай байсан ба оны эцэст 0,5 сая төгрөгийн авлагатай гарч авлага 19 хувиар өссөн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 53,3 сая төгрөгөөс 64,1 сая төгрөг болж 10,8 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 25,8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 18,5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1443,2 сая төгрөг, оны эцэст 1419,9 сая төгрөг болж 23,3 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Тайлант онд ОНХС-ийн санхүүжилтээр 5,0 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбайн өргөтгөл, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 8,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, Дэлхийн Зөн ОУБ-аас 0,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хандиваар 4,2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 6,3 сая төгрөгийн тавилга эд хогшил, ЕБС-иас 4 сая төгрөгийн сурагч сандал ширээг балансаас балансад шилжүүлэн авч нийт 28,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, аймгийн ИТХТ-ийн тогтоолоор 4,9 сая төгрөгийн, сумын ИТХТ-ийн тогтоолоор 5,9 сая төгрөгийн нийт 10,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Тайлант оны эхэнд 0,8 сая төгрөгийн өглөгтэй байсан ба оны эцэст 0,02 сая төгрөгийн өглөгтэй гарч оны эхний өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1496,1 сая төгрөг байсан оны эцэст 1484,6 сая төгрөг болж тайлант онд 11,5 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1132,7 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Манхан сумын хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 444,3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 444,3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 444,1 сая төгрөгөөр батлан ирүүлж, тайлант хугацаанд төсвийн тодотгол нэг удаа хийгдэж 405,6 сая төгрөг болж 38,5 сая төгрөгөөр буурсан.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 362,6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 42,9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 344,8 сая төгрөгийг зарцуулж 60,7 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 344,8 сая төгрөг буюу 85 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 21,1 сая төгрөгөөр, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3,7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,3 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0,1 сая төгрөгөөр, нормативт зардлыг 29,6 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,8 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 0,1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтын дансаар дээд шатны төсвийн захирагчаас 9,2 сая төгрөгийн өгсөний 8.5 сая төгрөг нь хөдөө орон нутагт ажилласны 2 хүний тэтгэмж, 0,7 сая төгрөг нь ариутгал халдваргүйжүүлэлтийн санхүүжилтийг боловсрол соёлын газраас өгсөн. Хөдөө орон нутагт ажилласан 2 хүний тэтгэмж 8.5 сая төгрөгийг багш Б.Ууганбаяр, туслах багш Ч.Соёл-Эрдэнэ нарт олгосон. Ховд жоли ХХК-д 0.4 сая төгрөг, Ягаан даль 0.2 сая төгрөг, Титэм плаза –д 0.1 сая төгрөгөөр ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авсан.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа мэдээллэж 8 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн байна. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг сайжруулж хоолны зардал болон бусад зардлаас зориулалт бусаар зарцуулах зөрчлийг бүрэн арилган ажиллаж байна. 2021 онд хүнсний нөөцөлсөн бүтээгдхүүн байхгүй ба дахин зөрчил гаргаж төсөвт хохирол учруулахгүй ажиллах байна. 2020 оны эцэст авлага 450,7 мянган төгрөг байсныг бүрэн барагдуулсан. Оны эцсийн өглөг 839,4 мянган төгрөгөөс 5,5 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж, урсгал засварын зардлын өглөг 833,9 мянган төгрөгийн өглөг санхүүгийн эх үүсвэр байхгүй учраас барагдахгүй байна. 2021 онд бусад санхүүгийн эх үүсвэр олох замаар уг өглөгийг барагдуулахад анхаарч ажиллана. 2021 оны эхний 5 сарын байдлаар 9 аж ахуйн нэгж, иргэнээс нийт 5382,4 мянган төгрөгийн бараа бүтээгдхүүн худалдан авсан бараа бүтээгдхүүнд И баримт авч зардлыг баримтжууллаа

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021.2.02-ний өдрийн А/06 тоот тушаалаар ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн 0.2 сая, 2021.02.04-ний өдрийн А/05 тоот тушаалаар ажилтан Л.Баясгаланд бэлэг 0.2 сая төгрөгөөр, 2021.12.20-н\_ы өдрийн А/22 тоот тушаалаар 20 хүнд түлээ нүүрсний хөнгөлөлт 5.9 сая төгрөг нийт 6.2 сая төгрөг олгосон нь засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3- дэх заалтыг зөрчсөн байна. Бараа материал 15 баримт 0.9 сая төгрөгөний И баримт аваагүй гүйлгээний хийснээр бүртгэв. 4 мэдээ 36.1 сая төгрөгийн мэдээлэл хугацаа хоцорсон. 4 нь 8 сард хоцорсон байна Материаллаг бус алдаа гэж үзээд зөвлөмж өгөх

Аудитаар нийт 7.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7.1 сая төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 4.4 Дотоод хяналттай холбоотой асуудал

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 4.4.1 Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021.2.02-ний өдрийн А/06 тоот тушаалаар ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн 0.2 сая, 2021.02.04-ний өдрийн А/05 тоот тушаалаар ажилтан Л.Баясгаланд бэлэг 0.2 сая төгрөгөөр, 2021.12.20-н\_ы өдрийн А/22 тоот тушаалаар 20 хүнд түлээ нүүрсний хөнгөлөлт 5.9 сая төгрөг нийт 6.2 сая төгрөг олгосон

4.1 Өгсөн зөвлөмж Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 дахь урамшуулал олгохгүй байх " заалтыг мөрдөн ажиллах.

#### 4.4.2 И-баримтын бүрдүүлэлт

4.2 Илрүүлэлт: Бараа материал 15 баримт 0.9 сая төгрөгөний И баримт аваагүй гүйлгээний хийсэн зөрчил

4.2 Өгсөн зөвлөмж: "Татварын ерөнхий хуулийн 28.5.Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" заалтыг мөрдөн И баримтаар гүйлгээ хийж хэвших

Шилэн дэвцтэй холбоотой мэдээ

**4.3 Илрүүлэлт:** 4 мэдээ 36.1 сая төгрөгийн мэдээлэл хугацаа хоцорсон. 8 сард хоцорсон

**3.2 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Манхан сумын хүүхдийн цэцэрлэг	3	7.1	0	0.0			0	0	3	7.1

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:**

**Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:**

**А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР:**

**А.ОЮУНДЭЛГЭР**